



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитын нэр: “Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудит

ҮАГ- ХОА/2017/09-ГА

Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2017 оны А/12 дугаар тушаал, Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан



Сургалт, сурталчилгаа, мэдээлэлийг аж ахуйн нэгж байгууллага, ард иргэдэд мэдээлж байгаа боловч гэмт хэрэг гаралтын тоо буурахгүй байна.

**Ховд хот
2017 оны 10 сар**

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн тайлбар3
Ховд аймаг дахь Төрийн Аудитын газар	Аудит хийх үндэслэл, бүрэн эрх, хамрах хүрээ, зорилт, арга зүй.....4
Тэргүүлэх аудитор	Ерөнхий зүйл.....5
Л.Галбадрах	Бүлэг 1. Аймгийн хэмжээнд гарч байгаа гэмт хэргийн нөхцөл шалтгааныг тогтоож хийх ажлын төлөвлөгөө гарган сургалт, сурталчилгаа, мэдээлэлийг аж ахуйн нэгж байгууллага, ард иргэдэд мэдээлж байгаа боловч гэмт хэрэг гаралтын тоо буурахгүй байна.....6
Аудитын менежер	1.1. Аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний чиг үүргээ хууль эрх зүйн хүрээнд хэрэгжүүлэн ажиллаж байна.
А.Цэцэгсүрэн	Бүлэг 2: : Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн байгууллагуудын уялдаа холбоо сайжирсан боловч салбар зөвлөлийн ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.....10
Ахлах аудитор	2.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж байгаа хэдий ч иргэдийн хуулийн мэдлэгийг нэмэгдүүлж, камерийн хяналтын систетийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.
Д.Нарантуул	Бүлэг 3: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсвийг хуульд заасны дагуу баталсан ч хөрөнгийг зориулалт бусаар зарцуулжээ.....12
Аудитор	3.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсвийг хуульд заасны дагуу төлөвлөж баталсан байна.
Д.Эрдэнэцэцэг	Дүгнэлт.....15
2017 оны 10 дугаар сар	Зөвлөмж.....16
Уг тайланг УАГ-ын Веб сайт-аас үзнэ үү.	Зөрчлийн жагсаалт.....17
www.audit.mn	Тэргүүлэх аудиторовын тушаал18
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70433061 дугаарын утас дугаарын факсаар харилцана уу?	
ХАЯГ: Ховд аймгийн ЗДТГ-ын байр 3 давхарт	

Товчилсон үгийн тайлбар:

Товчилсон үг	Тайлбар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ГА	Гүйцэтгэлийн аудит
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ГХУСТХ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль
ГХУСАЗСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл
ОНЦ	Олон нийтийн цагдаа
ГХУССЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
НХҮХ	Нийгэм халамж үйлчилгээний хэлтэс
ХИС	Ховд Их Сургууль
НХУС	Í eéäÿì òçì ççí eýæeí óðààí û ñóðãóóëü
ГХС	Ãååååå òÿëí èé ñóðãóóëü
ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЭЛИЙН ЖАГСААЛТ	
Хүснэгт-1	Аймгийн хэмжээнд гарсан гэмт хэргийн судалгаа
Хүснэгт-2	Өрхийн орлого болон ажилгүй иргэдийн судалгаа
Хүснэгт-3	Сургалтанд хамрагдсан иргэд аж ахуйн нэгжийн тоо
Хүснэгт-4	2015-2017 оны батлагдсан төсөв
Хүснэгт-5	2015-2017 оны төсвийн зарцуулалт
Хүснэгт-6	Зориулалт бусаар зарцуулсан зардал

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй:

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх: Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2017 оны А/12 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Аймгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт: Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүнг шалгаж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийв. Үүнд:

- Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэх
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр үр дүнтэй эсэх
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төсвийн хөрөнгө үр ашигтай зарцуулагдсан эсэх

Аудитын хамрах хүрээ: Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар баримталж байгаа бодлого, судалгаа, шинжилгээ, статистик мэдээ, бусад баримт материалд үндэслэн аймгийн ИТХ, Аймгийн Прокурорын газар, Аймгийн Цагдаагийн газар болон бусад холбогдох байгууллагуудын 2015-2017 оны эхний хагас жилийн үйл ажиллагаа хамрагдаж аудит хийлээ.

Аудитын арга зүй: Аудитыг гүйцэтгэхэд төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС 3000-3100/-ийг ашиглах, холбогдох агентлаг, аймгийн ИТХ-ын холбогдох албан тушаалтнууд болон Прокурор, Цагдаагийн газрын ажилтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, үйл ажиллагааны тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Шалгуур үзүүлэлтүүд: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх журам, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөр, Цагдаагийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Прокурорын тухай хууль, Иргэний тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлийн тухай хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Төрийн аудитын тухай хуулиуд болон хуулиудтай нийцүүлэн гаргасан дүрэм, журам, холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн: Аудитыг Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Л.Галбадрах удирдан, аудитын менежер А.Цэцэгсүрэн аудитын арга зүйгээр хангаж, үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, Ахлах аудитор Д.Нарантуул, аудитор Д.Эрдэнэцэцэг нар гүйцэтгэв.

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ:

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлд нутгийн захиргааны байгууллагын чиг үүрэгт харьяа нутаг дэвсгэртэй гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажиллах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсвийн хэмжээг хянан баталж ажиллахыг хуульчилж өгсөн. Хуульд заасны дагуу аймгийн ИТХТ-ын 2013 оны 45 дугаар тогтоолоор аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийг дарга, дэд дарга, нарийн бичиг, гишүүдийн хамт 17 албан тушаалтаны бүрэлдэхүүнтэй баталжээ.

ГХУСЗөвлөл нь 2016 онд 6 бүлэг 29 заалт ажил төлөвлөн аймаг, сумд, багийн нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, олон нийт цагдаагийн хамтын ажиллагааг сайжруулах, хууль эрх зүйг сурталчлан таниулах зорилгоор хийгдэх ажлын удирдамж, төлөвлөгөө гарган батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Тайланд онд тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг илрүүлж, хуулийн дагуу хариуцлага тооцох, согтууруулах ундаа, тамхи худалдаалах тусгай зөвшөөрлийн хугацаа, олголтыг үзэж шалгах, зөвшөөрлийн бус цэгт архидан согтуурсан иргэдийг журамлах, байгууллага, аж ахуйн нэгжийн харуул хамгаалалтыг шалгах, аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавин ажиллажээ.

Дээрхи арга хэмжээний хүрээнд давхардсан тоогоор 468 аж ахуйн нэгжийг шалган, харуул хамгаалалтаа сайжруулах талаар болон 22 удаа 1752 иргэнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх яриа таниулга хийж, иргэд олон нийтэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 285 ширхэг санамж, сэрэмжлүүлэг тараан өгч, орон нутгийн 2 телевизээр 4 удаа нэвтрүүлэг мэдээ бэлтгэн олон нийтэд хүргэн ажилласан байна.

Аймгийн хэмжээнд 2015 онд нийт 6130 гомдол иргэдээс ирж 498 гэмт хэрэг бүртгэсэн бол, 2016 онд 4816 гомдол иргэдээс ирж 398 гэмт хэрэг бүртгэгдэж гэмт хэргийн тоо 20.1 хувиар, гомдлын тоо 21.4 хувиар тус тус буурчээ.

2017 оны эхний хагас жилийн мэдээгээр 2584 гомдол иргэдээс ирснээс 246 гэмт хэрэг бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс гэмт хэргийн тоо 27.5 хувиар, гомдол мэдээлэлийн тоо 8.5 хувиар өссөн байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 2015 онд 61.8 сая, 2016 онд 59.2 сая, 2017 онд 68.1 сая төгрөгийг тус тус баталж, гүйцэтгэлээр 2015 онд 54.9 сая, 2016 онд 65.2 сая, 2017 онд 31.4 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

Бүлэг 1: Аймгийн хэмжээнд гарч байгаа гэмт хэргийн нөхцөл шалтгааныг тогтоож хийх ажлын төлөвлөгөө гарган сургалт, сурталчилгаа, мэдээлэлийг аж ахуйн нэгж байгууллага, ард иргэдэд мэдээлж байгаа боловч гэмт хэргийн тоо буурахгүй байна

Аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний чиг үүргээ хууль эрх зүйн хүрээнд хэрэгжүүлэн ажиллаж байна.

1.1. Аймгийн ИТХ–ын хурлаас 2015-2017 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтийг хангах, сум, багийн нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, олон нийт цагдаагийн хамтын ажиллагааг сайжруулах, хууль эрх зүйг сурталчлан таниулах зорилгоор уг арга хэмжээний удирдамж, төлөвлөгөө гарган батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллажээ.

Энэ хугацаанд тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг илрүүлж, хуулийн дагуу хариуцлага тооцох, согтууруулах ундаа, тамхи худалдаалах тусгай зөвшөөрлийн хугацаа, олголтыг үзэж шалгах, зөвшөөрлийн бус цэгт архидан согтуурсан иргэдийг журамлах, байгууллага, аж ахуйн нэгжийн харуул хамгаалалтыг шалгах, аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавих ажлуудыг хийсэн байна.

ГХУСЗ болон хууль хяналтын байгууллагууд аймгийн хэмжээнд гарч байгаа гэмт хэргийн нөхцөл шалтгааныг тогтоож хийх ажлын төлөвлөгөө гарган сургалт, сурталчилгаа, мэдээлэлийг аж ахуйн нэгж байгууллага, ард иргэдэд мэдээлж байгаа боловч гэмт хэрэг гаралтын тоо буурахгүй байна.

Хүснэгт 1

Үзүүлэлт	2017 оны эхний хагас жил	2016 оны эхний хагас жил	Өсөлт бууралт хувь	2015	2016	Өсөлт бууралт хувь
Нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл	2584	2377	8.7%	6130	4816	-21.4%
Бүртгэгдсэн гэмт хэрэг	246	193	27.5%	498	398	-20.10%
Илрээгүй гэмт хэрэг	34	20	70.0%	31	40	29%
Илрүүлэлтийн хувь	63.5	63.0	50.0%	68.4	65.2	0.3
Согтуугаар үйлдэгдсэн	67	49	36.7%	132	118	-10.6%
Бүлэглэн үйлдэгдсэн	9	8	12.5%	42	14	-66.6%
Галт зэвсгээр үйлдэгдсэн	4	3	33.3%	2	3	50.0%
Гэр бүлийн хүчирхийлэлийн улмаас	11	14	-21.4%	28	33	17.8%
Хүүхэд оролцсон	8	11	-27.3%	18	19	5.5%

Дээрхи хүснэгтээс харахад гэмт хэргийн тоо 2015 оноос 2016 онд гарсан зарим гэмт хэргийн тоо буурсан боловч 2017 оны эхний хагас жилийн байдлаар гэмт хэрэг өссөн байна.

Гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нь	Хүснэгт 2 Өсөлт бууралт		
ажилгүйчүүдийн тоо 2949-өөр нэмэгдсэн, иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дутмаг, өрхийн орлого 59.1 мянган төгрөгөөр буурсан, айл хөршийн холбоо муу зэрэгтэй холбоотой байна.	Үзүүлэлт	2016	2015
	Өрхийн сарын дундаж орлого	655.8	714.9
	Ажилгүйчүүдийн тоо	6056	3107
			2949

Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах талаар сургалт, сурталчилгааны ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлж ажилласан байна.

1.2. Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах нийгэм, эдийн засгийн эрх зүйн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн хэмжээнд зохион явагдаж буй “Архи, тамхигүй Ховдчууд” аян, Монгол Улсын Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, Тамхины хяналтын тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, багийн засаг дарга, хэсгийн байцаагч, нийгмийн ажилтан, иргэдийн хамтын ажиллагааг сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах, хууль эрх зүйг сурталчлан сургалт, яриа таниулга, мэдээ, мэдээлэл хийх, уралдаан тэмцээн зохион явуулах зорилгоор “Иргэдэд хууль эрх зүйг сурталчлан таниулах нь” 2 сарын аяны удирдамж гарган батлуулан холбогдох газарт хүргүүлэн, хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Прокурорын газраас гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар төрийн болон төрийн бус байгууллага аж ахуй нэгжид прокурорын мэдэгдэл хүргүүлж биелэлтийг тооцож, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө гарган батлуулж мөн орон нутгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн төлөвлөгөөнд санал хүсэлтээ өгч тусгуулан ажиллаж байна. Жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг улирал бүрээр төлөвлөгөө гарган тухай бүр хийж гүйцэтгэн ажиллаж сумдын иргэдэд хууль, сурталчлах, шинээр мөрдөгдөж буй хуулиудын талаар нээлттэй өдөрлөг зохион байгуулж, гарын авлагуудыг тараан өгчээ.



Хууль хяналтын байгууллагуудаас захиргааны хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж сургалт мэдээлэлийг тогтмол өгснөөр хорих ял эдлээд суллагдсан иргэд давтан гэмт хэрэгт холбогдоогүй байна.

1.3. Цагдаагийн газрын захиргааны хяналтанд 2015 онд 100, 2016 онд 69, 2017 онд 78 хүн бүртгэгдсэн байна. Эдгээр хүмүүсийг нийгэмшүүлэх, дахин гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор сар бүр хариуцсан хэсгийн байцаагч, төлөөлөгч нар уулзан зөвлөгөө өгч, хяналт тавин ажилласны үр дүнд 2015-2016 онуудад давтан гэмт хэрэг үйлдэгдээгүй байна.

Захиргааны хяналтанд байгаа хүмүүст аймгийн НХҮХ-ээс 26 хүнд эд материалын болон мөнгөн тусламж олгуулж, захиргааны хяналтанд байгаа нэг хүнийг амьжиргаа дээшлүүлэх төсөлд хамруулсан, хорихоос суллагдсан 2 хүнийг Политехник коллежийн хүнд машин механизм, барилгын ангид элсүүлэн суралцуулж, 6 хүнийг улирлын чанартай барилгын ажилд хамруулсан байна.

Иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулж иргэдэд мөнгөн урамшуулал олгон оролцоог ханган ажилласан байна.

1.4 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэн болон аж ахуйн нэгжтэй хамтран аймгийн ИТХ-аас ХИС-ийн НХУС-ийн Нийгмийн ухааны тэнхимийн Эрх зүйн ангийн оюутан, багш нартай хамтран “Мэргэжил сурталчлах-хуулийн өдөрлөг”, “Ёс зүйн тухай ойлголт”, “Хувь хүний төлөвшил, зан суртахуун” сэдвээр мэдээлэл сургалт зохион явуулж, оюутнууд үе тэнгийнхэндээ хууль эрх зүйн зөвлөгөө өгч, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөмж, гарын авлага материал тараан өгсөн бөгөөд оюутнуудын сонирхсон асуултанд хариулт өгч, харилцан ярилцлага хийжээ.



Аймгийн Прокурорын газраас иргэд болон аж ахуй нэгж байгууллагуудыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд оролцуулах зорилгоор нээлттэй өдөрлөг зохион байгуулж хууль сурталчлан, яриа таниулга хийж, Төрийн болон төрийн бус байгууллага аж ахуй нэгжид гэмт хэрэг гарсан шалтгаан нөхцөлийг арилгуулахаар прокурорын мэдэгдэл бичиж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тодорхой ажил зохион байгуулжээ.

Цагдаагийн газраас Дэлхийн байгаль хамгаалах сангийн Алтай Соёны бүс, Ховд аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Байгаль орчин, аялал жуучлалын газартай хамтран Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн эрхлэгч нарыг оролцуулан “Замын хөдөлгөөн хүүхэд” сэдэвт уулзалт хэлэлцүүлэг, “Зам тээврийн осол - хүүхэд” сэдэвт нэвтрүүлэг, “Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлье” талбайн гар зургийн уралдаан, “Замын хөдөлгөөний дүрмийг хэн сайн мэдэх вэ” АХА тэмцээннийг тус тус зохион явуулж, тэргүүлсэн сурагчдыг шагнаж урамшуулсан. Мөн аймгийн авто жолооны сургуулиудтай хамтран “Зам тээврийн осол”-ын хор уршгийг харуулсан самбар, үзүүлэн бэлтгэн олон нийтэд сурталчилж, сэрэмжлүүлэг, зөвлөмж тараан өгсөн.



Иргэдийн хамтын ажиллагааг сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах, хууль эрх зүйг сурталчлах зорилгоор орон нутгийн телевизийн байгууллагуудтай хамтран нэвтрүүлэг бэлтгэж олон нийтэд хүргэсэн байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 13.1¹-д заасны дагуу аймгийн 17 суманд олон нийтийн цагдаа ажиллуулж сар бүр хийсэн ажлын тайлангаа ирүүлсний дагуу мөнгөн урамшуулалыг тухайн иргэдэд олгож хэвшжээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаархи сургалт сурталчилгаа, мэдээлэлийг олон нийтэд түгээж байгаа ч үр дүн төдийлөн сайжирахгүй байна.

1.5 Хууль тогтоомжийг сурталчилах арга хэмжээний хүрээнд 2015-2017 онуудад аймгийн ГХУСЗөвлөл, Прокурор, Цагдаагийн газар болон бусад хууль хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлье”, “Хулгайн гэмт хэргийн тухай ойлголт түүнээс

он	сургалтын тоо	сургалтанд хамрагдсан хүний тоо /давхардсан тоогоор/	Хүснэгт 3
			сургалтанд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын тоо /давхардсан тоогоор/
2017	14	10206	27
2015	74	18785	63
2016	37	12980	51
нийт	125	41971	141

урьдчилан сэргийлье”, “Архи-эрүүл мэнд”, “Насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлье”, “Зам тээврийн осол зөрчлөөс сэргийлье”, “Мал хулгайлах гэмт хэргээс сэргийлье”, “Хүүхдийн эрх ба үүрэг” гэсэн 125 удаагийн сургалтыг зохион байгуулж 141 аж ахуйн нэгж байгууллагуудын 41971 алба хаагчид болон иргэдийг хамруулсан байна.

Мөн мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулиудыг хэрэгжүүлэх, иргэд олон нийтэд ойлгон таниулах, малын хулгайн гэмт хэргийн талаар мэдээ мэдээлэл цуглуулах, малчдын эрх ашгийг хамгаалах, иргэдийг хулгайн мал, мах, түүхий эд худалдан авахаас урьдчилан сэргийлэх талаар мэдээ мэдээлэл өгөх зорилгоор “Мал хулгайлах гэмт хэргээс хамтдаа сэргийлье” сэдэвт сургалт, уулзалт ярилцлагыг аймгийн “Дэлхийд цорын ганц нүүдэлчин Монгол холбоо”-той хамтран зохион явуулж, Ховд телевизээр нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд хүргэж ажилласан байна.

Аймгийн хэмжээнд малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 36, байгаль орчны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 1, хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 4 бүгд 41 сайн дурын бүлгэм ГХУЗөвлөл болон Прокурор, Цагдаагийн газартай хамтран ажиллаж байна

Сургалт сурталчилгааг тодорхой нэгэн хэлбэрээр олгож байгаа боловч гэмт хэргийн тоо өсөж байгаа гол шалтгаан нь иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дутмаг, ажилгүйчүүдийн тоо нэмэгдсэн, хувь хүний амьжиргааны түвшин буурсан, архидан согтууралт нэмэгдсэн зэрэг нийгмийн хүчин зүйлийн нөлөөлөл их байна.

¹ 13.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэнийг дор дурдсан хэлбэрээр урамшуулна

Бүлэг 2: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн байгууллагуудын уялдаа холбоо сайжирсан ч салбар зөвлөлийн ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж байгаа ч цаашид иргэдийн хуулийн мэдээлэлийг нэмэгдүүлж, камерийн хяналтын системийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

2.1 Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл нь 2016 онд хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан, 2017 оны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг хэлэлцэн баталжээ. Төлөвлөгөө боловсруулахдаа тухайн онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нийтийн дэг журам хамгаалах асуудлаар юунд анхаарч, ямар ажил зохион байгуулах талаар салбар зөвлөлийн гишүүн байгууллагууд, Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсээс санал авч, Зохицуулах зөвлөлийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулан батлуулж, зөвлөлийн гишүүдэд хүргүүлсэн бөгөөд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлж буй ажлын мэдээ, тайланг улирлаар нь авч ажилласан байна.



Аймгийн Прокурорын газраас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн төвийн албан байгууллага болон гудамж талбайг камержуулах мэдэгдэх хуудас өгч биелэлтийг тооцон ажиллаж шинэлэг арга хэлбэрийг хэрэгжүүлжээ. Тухайлбал: Замын цагдаагийн зарим хэсэг, БОЭТ, сургууль, цэцэрлэг, банк, хувийн дэлгүүр, ААН-үүд камертэй болсон байна.


Цаашид аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хэргийг илрүүлэхэд камерийн системийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Цагдаагийн байгууллагаас нэвтрүүлсэн шинэлэг ажил, арга хэмжээний хүрээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймаг, орон нутгийн удирдлагууд санал хүргүүлж холбогдох шийдвэр, тушаалыг гаргуулан хэрэгжүүлсэн байна.

Хууль сахиулах байгууллагуудын ажлын уялдаа холбоо хуулийн хүрээнд чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж чиг үүргийн давхардалгүй ажилласан байна.

2.2 Хууль сурталчлах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Прокурорын байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд хүргэх зорилгоор аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Сум дундын анхан шатны шүүх, Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Гадаадын иргэн харъяатын газар, Шүүхийн шинжилгээний алба зэрэг байгууллагуудыг хамруулж "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг зохион байгуулан,

иргэдээс гаргасан санал, хүсэлтийг хүлээн авч, зарим төрийн үйлчилгээг газар дээр нь үзүүлжээ.



ажилласан байна.

Орон нутгийн хэмжээнд “Сургуулийн цагдаа” эргүүлийн ажиллах журмыг хэрэгжүүлэх, ерөнхий боловсролын сурагчдыг сургуулийн орчинд гэмт хэрэг, зөрчилд холбогдох, өртөх, эрх ашиг нь хохирох, хэв журам зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх ажилд сурагчдын эцэг, эх, сургуулийн ажилтан, алба хаагч нарыг татан оролцуулан

Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудлаарх эрх зүйн орчны шинэчлэлтийн хүрээнд Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн төсөл боловсруулагдаж байгаатай холбогдуулан төрийн байгууллагын төлөөлөл болон эцэг эх, иргэдийн төлөөлөл нийт 50 хүн оролцуулсан хэлэлцүүлгийг зохион байгуулан ажилласан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

2.3 Аймгийн ИТХ-аас аймгийн Засаг даргын 2017 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн 01 дүгээр албан даалгавар гаргуулж, Захиргааны ерөнхий хууль хэрэгжүүлэх талаар 1 дүгээр улиралд зохион байгуулсан ажлын тайланг 17 сум байгууллагаас хүлээн авч дүгнэлт хийн Захиргааны ерөнхий хуулийг судлан мөрдөж хэрэгжүүлэх зөвлөмж хүргүүлэн ажиллажээ.

Аймгийн ИТХ-ийн ажлын албанаас сумдын ГХУСАЗСЗ-ийн ажлыг эрчимжүүлэх, нэгдсэн удирдлагаар ханган ажиллах чиглэлийг “Цаг үеийн ажлыг эрчимжүүлэх тухай” 2017 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 2/31 тоот албан бичгээр сумдад хүргүүлж ажилласан бөгөөд уг ажлын хүрээнд сумдын ГХУСАЗСЗ шинэчлэн байгуулагдаж, ажиллах журмыг батлан хэрэгжүүлж ажилласан байна.



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 27 дугаар тогтоолоор “Сумын ИТХ болон багийн ИНХ-ын үйл ажиллагааг үнэлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх журам”-ыг баталсан бөгөөд энэхүү журмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн ИТХ-ын ажлын албаны ажлын хэсэг аймгийн 11 суманд ажилласан байна. Тус ажлын хэсэг удирдамжийн дагуу ажилласан бөгөөд энэ үеэр сумын ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагаатай танилцаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн байна.

Аймгийн ГХУС салбар зөвлөл байгуулагдаж тодорхой ажлуудыг хэрэгжүүлсэн ч дараах зөрчил дутагдлыг анхаарах шаардлагатай байна. Үүнд:

- Тус салбар зөвлөл нь 2016 онд 1 удаа, 2017 онд 1 удаа хуралдаж ажлын төлөвлөгөө баталж өмнөх оны тайлангаа хэлэлцсэнээс үзэхэд бусад шаардлагатай асуудлуудаар хэлэлцсэн асуудал байхгүй байна.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл нь бусад байгууллагуудтай хамтарч ажиллах гэрээ хийгээгүй, баталсан төлөвлөгөөнийхөө дагуу ажлаа бүрэн хийгээгүй байна. Тухайлбал: 2016 оны төлөвлөсөн 29 ажлаас 10 ажил хийгдээгүй байна.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл нь сумдын салбар зөвлөлөөс санал авч ажлын төлөвлөгөөндөө тусгахаар заасан заалтын хэрэгжилт хангалтгүй байна.
- Иргэдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллээр хангах, сургалт сурталчилгаа алслагдсан суманд болон малчдад бүрэн хүрч очиж чадахгүй байна.

Бүлэг 3: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсвийг хуульд заасны дагуу баталсан ч хөрөнгийг зориулалт бусаар зарцуулжээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсвийг хуульд заасны дагуу төлөвлөж баталсан байна.

3.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19.1²-д заасны дагуу Аймгийн ИТХ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 2015 онд 61.8 сая төгрөг, 2016 онд 59.2 сая төгрөг, 2017 онд 68.1 сая төгрөг батлагдсан байна.

Аймгийн хүү торгуулийн орлогоос 2015 онд орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 150.2 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 176.2 сая төгрөг орж 26.0 сая төгрөгөөр орлогоо давуулан биелүүлсэн байна. 2016 онд 150.2 сая төгрөг төлөвлөгдөж 247.8 сая төгрөгийн орлого орж төлөвлөгөөгөө 97.6 сая төгрөгөөр давуулан

Хүснэгт 4

/сая төгрөг/

д/д	Огноо	Төлөвлөгөө	Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын			ГХУСТХ-ийн 19-р зүйлийн 19.1-д заасны дагуу орон нутгийн төсвөөс авсан санхүүжилтийн дүн
			Гүйцэтгэл			
			Бэлэн	Бэлэн бус	Нийт	
1	2015	150.2	176.3		176.3	61.8
2	2016	150.2	228.3	19.6	247.9	59.2
2	2017 -1-6 сар	150.2	74.8	79.2	153.9	68.1

² 19.1. Тухайн жилд шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр улсын орлого болгосон, торгох ял ногдуулж төсөвт тушаасан мөнгөний 40 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан дараагийн жилийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

биелүүлжээ. 2017 онд 150.2 сая төгрөг төлөвлөгдсөнөөс эхний хагас жилийн байдлаар 153.9 сая төгрөг орж төлөвлөгөөгөө 3.7 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын санхүүжилт 2015-2017 онуудад бүрэн батлагдсан боловч төсвөө зориулалт бусаар зарцуулжээ.

3.2 ИТХ-аас өгсөн мэдээгээр 2015 онд 61.8 сая төгрөг батлагдсанаас иргэд байгууллагын дунд зохиосон сургалт, сурталчилгааны зардлыг санхүүжүүлэхэд 17.1 сая төгрөг, эргүүл, ОНЦ-ийн ажилтныг урамшуулахад 14.3 сая төгрөг, тэтгэвэр тэтгэмжийн зөрүү зардал нөхөн төлбөрийг төлөхөд 1.6 сая төгрөг, бусад олон нийтийн ажилд 20.1 сая төгрөг, 2016 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хууль сурталчлах хууь сахиулах болон бусад байгууллагуудтай хамтран сургалт зохион байгуулсан 12.6 сая төгрөг, эргүүл ОНЦ-ийн урамшуулалд 15.6 сая төгрөг, цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд шаардлагатай техник хэрэгсэл мэдээлэл авах зардалд 5.4 сая төгрөг бусад олон нийтийн ажилд 20.2 сая төгрөг, 2017 онд сургалт мэдээлэлийн зардалд 7.1 сая төгрөг, эргүүл ОНЦ-ийн урамшуулалд 11.2 сая төгрөг, тэтгэвэр тэтгэмжийн зардалд 0.8 сая төгрөг, бусад олон нийтийн ажилд 14.8 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 5

д/д	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	Он	Орлогын эх үүсвэр	/сая төгрөг/		
				Зарцуулалт		
				Сургалт зохион байгуулсан зардал	Олон нийтийн цагдаагийн цалин	Бусад зардал
1	Орон нутгийн төсөв	2015	61.8	17.1	17.5	27.2
2	Орон нутгийн төсөв	2016	59.2	12.6	15.7	30.9
3	Орон нутгийн төсөв	2017-1-6	68.1	7.1	11.2	49.8

Зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримтаар хянахад дараах зөрчлүүд байна. Үүнд:

- 2015 онд 20.1 сая төгрөг, 2016 онд 51.1 сая төгрөг, 2017 онд 25.4 сая төгрөгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал болон сургалт, мэдээлэл өгөхөд зарцуулсан байна. Дээрх баримтын анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээ хийсэн, тушаал шийдвэргүй, гарын үсэг зурж баримтжуулаагүй ажил гүйлгээ хийсэн
- 2015 онд 12.3 сая төгрөг, 2016 онд 13.7 сая төгрөг, 2017 онд 4.6 сая төгрөгийг хуульд нийцүүлэн ГХУС арга хэмжээний зардалд зарцуулаагүй бусад шүүхийн шийдвэр, шатахуун зардал, ашгийн татвар, томилолт, хоол зэрэгт зарцуулсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зарцуулагдсан төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдсан байна.

3.3 2015 онд 54.9 сая төгрөг төсөвт батлагдсанаас 20.2 сая төгрөгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд, 12.3 сая төгрөгийг зориулалт бусаар, 2016 онд 59.1 сая төгрөг батлагдсанаас 45.1 сая төгрөгийг урьдчилан сэргийлэх зардалд, 13.7 сая төгрөгийг зориулалт бусаар, 2017 онд 34.1 сая төгрөг зарцуулахаас 28.2 сая төгрөгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд зарцуулж 4.6 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Хүснэгт 6

д/д	Он	Батлагдсан төсөв	Нийт зарцуулсан	/сая төгрөг/					
				Зарцуулалт					
				ГХУСТХ зардал	Зориулалт бусаар				
					НДШ	Замын зардал	Шүүхийн шийдвэр	Материалын зардал	Анхан шатны баримтгүй /бусад/
1	2015	61.8	54.9	39.3	3.3	1,1	6,9	3,1	1,2
2	2016	59.2	65.2	47.1	4.4	1.4	7,2	3.0	2,1
3	2017	68.1	31.4	25.3	2.3	1.3	0	1.3	1.2

Дээрхи хүснэгтээс харахад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын зарцуулалт зориулалт бусаар зарцуулагдсан дараах зөрчил дутагдал байна. Үүнд:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас шүүхийн шийдвэрээр ажлаас халагдсан хүмүүсийн нөхөн төлбөр болох 7.2 сая төгрөг зориулалт бусаар олгосон боловч хуулийн сургалт сурталчилгааны зардалд 2.1 сая төгрөг зарцуулсан нь хангалтгүй байна.
- Олон нийтийн цагдаагийн эргүүл хийсэн хүмүүсийн цалинд 2015-2016 онд 18.1 сая төгрөгийг зарцуулсан ч ажиллах хүний тоо, урамшуулалын хэмжээг ИТХ тогтоогоогүй байна. Мөн зарим олон нийтийн цагдаагийн хийсэн ажлын тайлан мэдээ байхгүй байна.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас замын зардал томилолтонд 3.8 сая төгрөг, материал худалдан авсан 7.4 сая төгрөг зарцуулсан байгаа нь тушаал шийдвэргүй, тайлан баримтгүй ямар зардал санхүүжүүлээд байгаа нь мэдэгдэхгүй зориулалт бусаар зарцуулсан байна.
- Анхан шатны баримтгүй 4.5 сая төгрөг зарцуулсан байгаа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг санхүүжүүлээгүй төсвийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулсан байна.
- 2016 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас Мянгад сумын ЗДТГазарт адууг омгоор баталгаажуулах зардалд 3.2 сая төгрөг олгосон байгаа нь ГХУСТХ-ийн 19,4-р зүйл заалтыг зөрчсөн байна.

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 2012 оны 524 тоот шүүхийн шийдвэрийн дагуу иргэн Н.Дамбад 2015 онд 4.1 сая төгрөг, 2016 онд 1.6 сая төгрөг, 2017 онд 1.2 сая төгрөг, бүгд 6.9 сая төгрөг зарцуулсан байгаа нь хууль эрх зүйн үндэслэлгүй төсвийн үргүй зардал гаргасан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдсан төсвийн хөрөнгөд тавих хяналт сул байна.

3.4 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал батлагдсан төсвийн дагуу хуульд зааснаар зарцуулагдаагүй түүнд тавих хяналт байхгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл төсвийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллаагүй дараах зөрчлүүд байна. Үүнд:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан олгосон хөрөнгийг зориулалт бус зүйлд зарцуулсан,
- Орлогын гүйцэтгэлийг гаргаж санхүүгийн байгууллагад хүргүүлэх бөгөөд санхүүгийн байгууллага гүйцэтгэлийг тайлантай тулган шалгаж хүлээн аваагүй, салбар зөвлөлөөр хэлэлцэж баталгаажуулаагүй,
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг зориулалт бус зүйлд зарцуулсан албан тушаалтанд хариуцлага тооцоогүй,
- Төрийн захиргааны болон хууль сахиулах байгууллагуудын удирдах ажилтны зөвлөлгөөнийг тодорхой хугацаанд зохион байгуулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлт, үр дүнг хэлэлцэн, цаашид авах арга хэмжээг хамтран төлөвлөх бодлого хангалтгүй байна.

Аудитын явцад дээрхи зөрчил дутагдалтай холбоотой 2015 онд 12,3 сая төгрөг, 2016 онд 13,7 сая төгрөг 2017 онд 4,6 сая төгрөг нийт 30,6 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрсэнээс 17.3 сая төгрөгийн албан шаардлага бичиж 13.3 сая төгрөгийн зөвлөмж өгөгдлөө.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- ***Аймгийн хэмжээнд гарч байгаа гэмт хэргийн нөхцөл шалтгааныг тогтоож хийх ажлын төлөвлөгөө гарган сургалт, сурталчилгаа, мэдээлэлийг аж ахуйн нэгж байгууллага, ард иргэдэд мэдээлж байгаа боловч гэмт хэрэг гаралтын тоо буурахгүй байна***
- ***Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн байгууллагуудын уялдаа холбоо сайжирсан ч салбар зөвлөлийн ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.***

- **Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсвийг хуульд заасны дагуу баталсан ч хөрөнгийг зориулалт бусаар зарцуулжээ.**

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн ГХУСАЗСЗ-ийн дарга Г.Пүрэв-Гандид:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэдийн насны онцлог, сонирхолыг харгалзсан, зорилтот бүлгүүдэд чиглэсэн, мэдээлэл, сурталчилгааг чанартай, хүртээмжтэй хийж үр нөлөөг дээшлүүлэх
2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлд багтдаг байгууллагуудтай /ЭМГазар, ХХГБХХэлтэс, Өмгөөлөгчдийн холбоо, ЗДТГазар, Онцгой байдлын газар, Прокурорын газар, Цагдаагийн газар, ШШГАлба, Шүүх, Боловсролын газар гэх мэт/ харилцан уялдаа холбоотой ажиллан мэдээллийн сантай болох
3. ГХУСТХ-ийн 19-р зүйлд заасан төсөв зарцуулах заалтын хэрэгжилтийг хангаж, 19.4-д заасан хуулийн хэрэгжилтийг биелүүлж ажиллах
4. Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгуулагатай хамтран ажиллаж хууль сурталчлах цагийг тогтмол явуулж иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх
5. Санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлж аудитын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, дахин гаргахгүй байх арга хэмжээ авч хэрэгжүүлэн аймгийн Төрийн аудитын газарт 2017 оны 12-р сарын 25-ны дотор мэдэгдэх

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ГАЛБАДРАХ

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР

Д.НАРАНТУУЛ

АУДИТОР

Д.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Албан шаардлагын товчоо